



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот


“Хүндэт тэмдэг” бий болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийг хөгжүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан хүмүүсийг шагнах Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг” шагналыг шинээр бий болгосугай.


2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг”-ээр шагнах журмыг нэгдүгээр, медалийн эх загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Медаль хийлгэх, дагалдах мөнгөн шагналд шаардагдах зардлыг Хурлын төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргах, цаашид Хурлын жил жилийн төсөвт тусгуулж ажиллахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Т.Баясгалан/- д даалгасугай.



ДАРГА

Д.БАТБИЛЭГ



Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 10
дугаар сарын 15 -ны өдрийн 81...
дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ЭЭР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг” /цаашид “Хүндэт тэмдэг” гэх/-ээр Хан-Уул дүүргийн хөгжил, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх, төр захиргааны байгууллагын ажиллагааг боловсронгуй болгох үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан хүнийг шагнана.

1.2. “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан хүнд үнэмлэх, дагалдах мөнгөн шагнал олгоно. Үнэмлэхэнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга гарын үсэг зурна. Дагалдах мөнгөн шагналын хэмжээ 50.000 /Тавин мянган/ төгрөг байна.

Хоёр. “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулахаар нэр дэвшүүлэх, шагнах


2.1. “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулахаар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Засаг дарга нар нэр дэвшүүлэх эрхтэй.

2.2. Хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тухайн Хурлын дарга, Тэргүүлэгчид болон дүүргийн хөгжил, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж байгаа хүмүүсийг шагнуулах асуудлыг хэлэлцүүлэн саналаа дүүргийн ИТХ-д хүргүүлнэ.

2.3. Дүүргийн хөгжил, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж байгаа хүмүүсийг шагнуулах саналыг төрийн болон төрийн бус, бусад байгууллагаас гаргаж болно.

2.4. Гадаадын иргэнийг шагнаж болно.

2.5. “Хүндэт тэмдэг”-ээр шагнуулах хүмүүсийн ажил байдлын тодорхойлолт, анкет, хамт олны хурлын тэмдэглэл, өргөн мэдүүлсэн албан бичиг болон холбогдох материалыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба хүлээн авч, бичиг баримтын бүрдэл, шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад урьдчилан танилцуулж, санал авсны дараа дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хурлын Тэргүүлэгчдэд дараа танилцуулах нөхцөлтэйгээр Хурлын дарга “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж болно.



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ийн ТОДОРХОЙЛОЛТ

Медалийн нийт өндөр 67 мм, өргөн 44мм-ийн харьцаатай, Л-63 маркийн цэвэр гуулиар хийгдэж, шар өнгийн уусмал түрхэцээр бүрэгдсэн давхар хийцтэй байна.

Медалийн лентний хэсэг 17 мм X 28 мм-ийн хэмжээний тэгш өнцөгт гүнзгий дөрвөлжин хөх өнгийн дэвсгэртэй, дээр нь крилл үсгээр “ХҮНДЭТ ТЭМДЭГ” гэж товойлгон бичнэ.

Лентний хоёр үзүүр алтан шар өнгийн хээгээр, доод хэсэг нь шар өнгийн цацраган хээгээр чимэглэгдсэн байна.

Медалийн их бие ϕ – 46 мм-ийн дугуй, түүний төвөөс гадагш чиглэсэн шовх ба мохоо өнцөгтэй алтан шар цацрагийг товойлгон сийлбэрлэсэн байна.

Цацрагийн голд дугуй хэлбэрийн тэмдэг давхарлан тавигдах бөгөөд түүний голд дүүргийн сүлд “ХАНГАРЬД” –ыг товойлгон дүрсэлж түүнийг тойруулан хөх өнгийн дэвсгэр дээр “ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ” гэж кирилл үсгээр бичиж, доод хэсэгт нь мөн чанарыг тодруулах зорилгоор чулуун шигтгээ суурилуулна.

Шовх өнцөгт цацраг нь амьдралыг тэтгэгч “нар” –ыг, мохоо өнцөг цацраг нь “сар”-ыг буюу зэндмэнэ эрдэнийг тус тус бэлгэдэх бөгөөд, мөнхөд цэцэглэн хөгжиж, мандан бадрахын төгөлдөр утгыг илэрхийлнэ.

Медалийн ар талд “Хан-Уул дүүрэг” гэсэн оноосон нэрийг дугуйруулан бичигдэж, голд нь “Өлзий” хээ байрлуулна. Дээд хэсэгтээ хувцсанд тогтоох булавкан зүүтэй байна.

Гурав. Бусад асуудал

3.1. “Хүндэт тэмдэг”-ээр шагнахтай холбогдон гарах зардлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт тусгасан байна.

3.2. “Хүндэт тэмдэг”-ийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга гардуулна.

3.3. “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан хүмүүсийн судалгааг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд хөтлөх бөгөөд шагнагдсан хүмүүсийн материалыг Хурлын архивт хадгална.